



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Гадаад харилцааны яамны  
2020-2024 оны Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Гадаад харилцааны яамны 2020-2024 оны Стратеги төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 3.1-д заасны дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, ДТГ-ын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг яам, ДТГ-ын тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх, Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад нөөц (хүн хүч, техник)-ийг төлөвлөн, хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, ДТГ-ын тэргүүн нарт даалгасугай.

4. Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг зохих журмын дагуу жил тутам гаргаж, “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 5.1-д заасны дагуу баталгаажуулах арга хэмжээ авахыг Бодлого, төлөвлөлийн газрын захирал Ш.Одонбаатар, Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын захирал Б.Баярсайхан нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Н.ЭНХТАЙВАН

080243